

ДЭД ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Энэ долоо хоногт багш нар маань дүнгээ гаргаж, ахлах ангийн сурагчид дипломын урьдчилсан шалгалтуудаа өгч, дунд сургуулийн сурагчид Хятадад сагсны тэмцээнд, Катарт MUN хуралд оролцохоор явлаа. Бага сургуулийн сурагчид маань хөгжимт жүжгийн тоглолтондоо бэлтгээд завгүй байна.

Сургууль дээр болж байгаа бүх үйл ажиллагааг нэг бүрчлэн би дурдсангүй. Та бүхэн илүү дэлгэрэнгүй мэдээллийг манай хичээлийн эрхлэгчдийн мэдээнээс болон Эцэг Эх Багш Нарын бүлгийн вэб сайтан дах мэдээллээс авах боломжтой. Манай хамт олон багш сурагчидгүй их завгүй ажиллаж Улаанбаатарт хүйтэн байгааг ч анзаарахгүй шахам байна.

Манай уламжлалт Цагаан Сарын Өдөрлөг 2 сарын 12-ны Баасан гарагт өглөө 8:30-д болно. Эцэг эхчүүд та бүхэн хүрэлцэн ирж манай өдөрлөгт оролцоорой.

Та бүхэнд сануулж хэлэхэд: Монгол эцэг эхчүүд болон Монголд удаан хугацаагаар оршин сууж байгаа эцэг эхчүүд хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төгрөгөөр хийх боломжтой. Энэ талаар бид вэб сайтан дахь элсэлтийн материалын сургалтын төлбөрийн мэдээлэлд оруулсан байгаа.

Шинэ дугуйлангууд ирэх долоо хоногоос хичээллэж эхэлнэ.

Та бүхэн сургууль дээр болох үйл ажиллагааны хуваарийг хуанлиасаа үзээрэй. Бид та бүхэнтэй сургууль дээрээ уулзахдаа баяртай байх болно.

Дэд Захирал, Туул Арлидий

Хуанлид Тэмдэглэх Өдрүүд:

2 сарын 2	Дунд ангийн сурагчдын үнэлгээний талаарх мэдээлэл-18:00 цагт
2 сарын 5	Сурагчдын дүн гарна
2 сарын 12	Цагаан Сарын Өдөрлөг-8:30
2 сарын 15, 16	Цагаан Сарын амралт, Хичээл орохгүй
2 сарын 18	Эцэг Эх Багш нарын хурал
2 сарын 23	ЭББ-ийн хурал-19:00 цагт
3 сарын 18	Бага Сургуулийн сурагчдын хөгжимт жүжгийн тоглолт

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Энэ долоо хоногт сагсны баг тамирчид маань Бээжинд болох ACAMIS тэмцээнд, MUN багийн сурагчид маань Катарт болдог хуралдаанд оролцохоор багш дасгалжуулагчдын хамт явлаа. Ахлах ангийн сурагчдын шалгалтууд дуусч дүнгүүд нь бичигдэж эхэлж байна. Сурагчдын дүн ирэх долоо хоногийн Баасан гарагт буюу 2 сарын 5-нд та бүхний гар дээр очно. Хэрвээ та бүхэнд багш нартай уулзаж асууж лавлах зүйл байвал сургууль руу утасдаж уулзалтын цаг товлоорой. Бид 2 сарын 18-нд эцэг эхийн хурал хийнэ. Та бүхэн манай багш нартай e-мэйлээр харилцах боломжтой. Та бүхэн хүүхдийнхээ сургалтанд анхаарч байдагт бид талархаж байна.

Сурагчдын дугуйлангууд ирэх долоо хоногт эхэлнэ. Дугуйлангийн талаарх мэдээллийг Лхагва гарагт сурагчдад өгч явуулсан. Та бүхэн хүүхдүүдээсээ ямар дугуйланд хамрагдсан, долоо хоногийн хэддэх өдрүүдэд хичээлийн дараа үлдэхийг нь асууж сонирхоорой.

Цаг агаарт тохируулж сурагчид маань дулаан хувцаслаж ирдэг болсонд бид баяртай байна. Гэхдээ олон сурагчид хичээлдээ усны савгүй ирж байна. Жилийн энэ улиралд хуурайшилт ихтэй байдаг тул сурагчид толгой өвдөж байна гэж гомдоллох нь элбэг байна. Энэ нь шингэн дутсаны анхны шинж тэмдэг байдаг. Хүүхдүүддээ усны савыг нь өгч явуулаарай. Усны саваа байнга авч явах нь сурагчдын эрүүл мэндэд тустай.

Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

**Дунд Сургуулийн Эрхлэгч
Betsy Hanselmann**

Дунд ангийн сурагчдын үнэлгээний талаарх мэдээлэл

Эцэг эхчүүд та бүхэнд зориулж 2 сарын 2-ны Мягмар гарагт орой 6 цагаас дунд ангийн сурагчдын 1-р семестрийн дүнгийн талаар мэдээлэл хийнэ. Дунд сургуулийн хөтөлбөрийн хүрээнд сурагчдын мэдлэгийг хэрхэн үнэлдэг аргууд болон үнэлгээний явцын талаар та бүхэнд мэдээлэл өгөх зорилгоор энэ уулзалтыг бид хийж байгаа юм.

Та энэ уулзалтанд ирж оролцох бол энэ тухайгаа d.chilton@isumongolia.edu.mn хаягаар мэдэгдэнэ үү.

**Дунд Ангийн Хөтөлбөрийн Зохицуулагч
Dave Chilton**

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Charlie and the Chocolate Factory

Багш нар жүжгийн зохиолыг найруулан тоглолтын бэлтгэл ажлуудыг хийгээд завгүй байна. Хөгжимт жүжгийн тоглолт хийхэд бидэнд эцэг эхчүүдийн тусламж хэрэгтэй байгаа талаарх захидлыг бид сурагчдаар явуулсан. Тоглолтын бэлтгэл, хөтөлбөрийн дизайн гаргаж хэвлэх, тоглолтын хувцас оюулах, тайз засах, нүүр будалт хийх зэрэгт бидэнд тусламж хэрэгтэй байгаа. Бидэнд туслахаа илэрхийлсэн эцэг эхчүүддээ талархаж байна. Та бүхэн тоглолтын ажилд туслах боломжтой бол хүүхдийнхээ ангийн багштай болон Ms. Kim Carroll-тай k.carroll@isumongolia.edu.mn хаягаар холбоо бариарай.

Цаг агаар хүйтэн байгаа тул бид ихэвчлэн сургууль дотроо тоглож байна. Гэхдээ хүйтний эрч гайгүй өдрүүдэд бид гадаа гарч тоглож байгаа. Сурагчид гадаа гарч тоглоход бэлтгэлтэй байж малгай, ороолт, бээлийгээ өмсөж дулаан хувцаслаж байх хэрэгтэй. Хэрвээ хүүхэд тань өвдсөн бол гэрт нь үлдээгээрэй. (жижүүр багш нар гадаа гарсан тохиолдолд сургууль дотор үлдсэн хүүхдийг харах боломжгүй). Зарим сурагчид гадаа малгай, бээлийгүй гарч байна. Иймээс та бүхэн хүүхдүүдээ тогтмол малгай, бээлийтэй явуулж байгаарай.

**Бага Сургуулийн Эрхлэгч
Jan Wiggins**

СУРАГЧДЫН ЗӨВЛӨЛӨӨС

Бид Олон Улсын Хатагтай нарын Нийгэмлэгийн төлөөлөгч хатагтай Constanze Zimmer-г цуглуулсан хандиваа гардуулж өглөө. Бидний хандивыг Хавдар судлалын эмнэлгийн өвчтөнүүдэд болон Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төвд байгаа ээж, хүүхдүүдэд түгээх болно. Хатагтай Zimmer амралтын үеэрээ бидний зохион байгуулсан хандивын арга хэмжээнд талархаж байна. Бид бүхэн ч гэсэн хандив цуглуулах энэ арга хэмжээнд оролцсон нийт эцэг эхчүүд, найз нартаа баярлалаа. Сурагчдын Зөвлөлөөс энэ арга хэмжээг тогтмол зохион байгуулахаар шийдсэн бөгөөд дараагийн амралтын үеэр өөр хандив цуглуулах арга хэмжээ зохион байгуулах болно.

**Сурагчдын Зөвлөлийн Дарга
Hiba Sayed**

4-р ангийн мэдээ

4-р ангийн хичээлийн сэдвийн үндсэн санаа: Хүн төрөлхтөн түүхийн явцад нэг орноос нөгөө оронд нүүн суурьшиж амьдран ирсэн билээ.

Энэ хичээлийн эхэнд сурагчид сургуулийн нэг хэсгээс нөгөө хэсэг рүү нүүн шилжих зөвшөөрлийн үнэмлэхийг хийж боловсруулав. Ингэснээр сурагчид нүүдэллэн суурьшихад янз бүрийн ойлгомжгүй шударга бус байдал байдгийг олж мэдэрсэн. Дараагийн туршилтын үйл явцад сурагчид илүү их хүндрэлтэй асуудлуудтай тулгарсан. 8-р ангийн сурагчид цэрэг дарангуйлагч нарын дүрд тоглож 4-р ангийн сурагчдыг өөрсдийн амьдран суурьшиж байгаа тосгоноос нь хүчээр хөөн тууж өөрийн эрхгүй газар нутгаа орхин дүрвэгсдийн хуаранд орогнох хэрэгтэй боллоо. Энэхүү жүжгэн туршилтын үеэр сургачид дүрвэгсдэд ямар их сэтгэл санааны хямрал, ойлгомжгүй хүндрэлтэй нөхцөл байдалд ордогийг мэдэрсэн.

Сурагчид хүмүүсээс нүүн суурьших талаар ярилцлага хийх асуултуудыг бэлтгэсэн. Тэд дэлхийн янз бүрийн орны хүмүүстэй ярилцлага хийх боломж олсон. Сурагчид Монголын цагаач иргэнтэй ярилцаж монгол малчин айлд зочилж тэдгээр хүмүүсийн өөрсдийн туршлагыг нь суралцлаа.

Финланд орноос дайны улмаас дүрвэсэн охинтой уулзаж, Вьетнамаас завиар дүрвэн нүүж Канадад амьдрах болсон цагаач иргэнтэй Skure-аар ярилцсанаар дэлхийн өнцөг булан бүрт нүүдэл суудал явагддаг болон дүрвэгсдийн хооронд олон ижил төстэй зүйл байдгийг олж мэдлээ.

Бидний хичээлийн судалгаа амжилттай хэрэгжихэд тусалсан 8-р ангийн сурагчид болон ярилцлага өгсөн бүх хүмүүст талархалаа илэрхийлье.

5-р ангийн мэдээ

Пүрэв гаригт бага ангийн цуглаанаар 5-р анги тусгай зочинг урьж авчирсан билээ. 5-р ангийн сурагчид “Шийдвэр” хэмээх хичээлийн үеээр хандив олох ажил зохион байгуулж олсон орлогоороо их сургуулийн оюутанг дэмжиж сурлагын төлбөрийг нь төлөх шийдвэр гаргасан. Энэ оюутанг Сангэрэл гэдэг бөгөөд тэрээр Дунд Говь аймгаас ирсэн. Сангэрэл нь Соёл Урлагийн Дээд Сургуульд суралцдаг бөгөөд бидэнд түүний дуулах авьяасыг нь сонсох боломж гарсан.

Сурагч Туяагийн санаачлагаар саяхан нэгэн айлийн гэр шатаж орох оронгүй болсон хүмүүст туслах зорилгоор 5-р ангийнхан тоглоом, хоол хүнс цуглуулах үйл ажиллагаа явуулсан билээ. Үүний хариуд энэ гэр бүлийхэн: “Бидний зовлонг хуваалцаж охин хүү хоёрт минь тусалсанд маш их баярлалаа. Та бүгдийн хичээл сургуульд амжилт хүсье. Баярлалаа. Төрөө, Саруул, Нандин, Номин нар” гэж талархал илэрхийлжээ.

“Багачуудад тоглоом өгцгөө”

Энэ жил АНУ-ын нь АНУ болон Британийн Элчин Сайдын шугамаар асрамжийн газрыг тэтгэх зорилгоор “Багачуудад тоглоом өгцгөө” хандив цуглуулах аянг явуулж байгаа билээ. Энэхүү аян нь нийгмийн эмзэг бүлэг болох өнчин хүүхдүүдэд тоглоом бэлэглэх зорилготой юм. Энэхүү хөтөлбөр нь АНУ-д маш амжилттай хэрэгждэг юм. Энэ нь хүүхдүүдэд Цагаан Сарын бэлэг болох юм.

Бүх хандивыг гэр орноосоо дүрвэн зугтсан буюу орон гэргүй хүүхдүүдийг асардаг Хүүхдийн “Verbist” төв рүү илгээнэ. Энэхүү асрамжийн төв нь 3-18 насны хүүхдүүдийг асран хүмүүжүүлдэг билээ. Та хандив өргөсөнөөр хамгийн зөв зүйлд сонголт хийж байна.

ОУС-ийн үүдний танхимд том хайрцаг байрлуулсан бөгөөд дотор нь сурагчид шинэ болон шинэвтэр тоглоом, хувцас болон хагас боловсруулсан хоол хүнс хийж болно. Мөнгөн хандив өгөх сонирхолтой хүмүүс АНУ-ын “Marine corps”-ийн ахмад Кристофер Хагантай 99042007 утсаар холбоо барьж уулзана уу.